

# Жэффри Р.Холландын “This Do in Remembrance of Me” үгнээс сонгож авсан хэсгүүд



“Хэрэв дурсан санах нь бидний чухал үүрэг юм бол бидэнд эдгээр ойлгомжтой, үнэ цэнэтэй БЭЛГЭ тэмдгийг санал болгох үед бид юуг санаж болох вэ?

“Бид Аврагчийн мөнх бус амьдралыг болон агуу Иеховагийн хувьд тэнгэр болон газар, түүнд орших бүхнийг бүтээсэн түүний бүх бүтээлийг дурсан санаж болно. Бид бас Тэнгэрийн агуу зөвлөлийн үед ч Тэрээр биднийг хайрлан, мөн гайхамшигийн хүч чадлыг үзүүлсэн болохыг, тэр үед бид Христийн хүч чадлаар болон Хурганы цусанд итгэх өөрсдийн итгэлээр ялан дийлснээ дурсан санаж болно (Илчлэлт 12:10–11-ийг үзнэ үү).

“Бид түүний мөнх бус төрөлтийн энгийн эрхэмсэг сүр хүчийг дурсан санаж болно. . . .

“Бид Христийн үйлдсэн гайхамшиг болон сургаалуудыг санаж болно. Мөн хүмүүсийг хэрхэн эдгээж, тусалж байсныг бид санаж болно. Тэрээр сохор нэгэнд хараа оруулж, дүлий нэгнийг сонсдог болгож, доголон, эрэмдэг, хатингар тэднийг хөдөлдөг болгосон гэдгийг бид санаж болно. Тийн, бидний өсөлт хөгжил зогссон, эсвэл бидний баяр хөөр болон үзэл бодол мохсон мэт санагдах үед бид Христэд туштай итгэн, урагш тэмүүлж чадна. . . .

“Бид Аврагч өөрт нь тийм чухал зорилго өгөгдсөн байхад ч хүртэл Тэрээр амьдралаас баяр хөөрийг олж, хүмүүсийг таалж мөн дагалдагчдаа баяр хөөртэй байхыг хэлсэн гэдгийг дурсан санаж болно. Бид хаалганыхаа босгон дээр агуу үнэт сувд олсон хүн шиг, сайн мэдээнд баярлах ёстой гэж Тэрээр хэлсэн. . . .

“Христ өөрийн дагалдагчдыг найз хэмээн нэрлэдэг байсныг бид дурсан санаж болно. . . .

“Бид амьдралдаа ирсэн гайхамшигтай зүйлсийг болон ‘сайн болох бүх зүйл Христээс ирдэг’ (Моронай 7:24) гэдгийг санаж болно, санах ч ёстой. . . .

‘Зарим үед түүнд хандаж байсан эелдэг бус харьцаа, түүнийг хавчин гадуурхаж байсан эсэргүүцэл, түүний тэвчиж байсан шударга бус зүйлс—тийм ээ, тэр шударга бус бүхэн бидэнд ч тохиолдож болно. Бидний амьдралд эдгээр зүйлийн зарим нь тохиолдох үед, Христийг бүх талаараа зовдог боловч няцардаггүй; сандардаг боловч цөхөрдөггүй; хавчигддаг боловч хаягддаггүй; цохигддог боловч мөхдөггүй байсныг бид санаж чадна (2 Коринт 4:8–9-ийг үзнэ үү).

“Эдгээр хэцүү цаг үе бидэнд ирэх үед бид Есүс Тэнгэрт дээш гарахаасаа өмнө тэрээр бүх зүйлийн доор бууж ирэх ёстой байсныг, мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчсэн гэдгийг; тэрээр бие махбодийн дагуу өөрийн хүмүүсийг тэдний сул байдлуудынх нь дагуу хэрхэн халамжлахыг мэдэж болохын тулд, тэрээр өөр дээрээ тэдний сул дорой чанаруудыг авсан гэдгийг санаж чадна (С ба Г 88:6; Алма 7:11–12-ыг үзнэ үү).

“Гуйвсан, эсвэл бүдэрсэн хүмүүсийг туйлбартай байлгаж, хүчирхэгжүүлэхийн тулд Тэр байдаг. Эцэст нь Тэр биднийг аврахаар амьд байгаа бөгөөд энэ бүхний төлөө өөрийн амийг өгсөн билээ. . . .

“. . . Залуу пристүүд Христийг үргэлж дурсан санахаар өвдөг сөгдөх үед бид эдгээр бүх зүйлийг дурсан санахад уригддаг билээ” (*Ensign*, 1995 оны 11-р сар, 67–69).